



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/191

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын 10 хоногийг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2018 оны 5 дугаар сарын 21-нээс 31-ний өдрүүдэд “Дархлаажуулалтын бүртгэл, мэдээллийг цахимжуулъя” уриан дор зохион байгуулсугай.
2. Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим програмыг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
3. Дархлаажуулалтын арав хоногоор заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолоос хоцорсон 15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулах, дархлаажуулалтын ач холбогдлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, эцэг эх, асран хамгаалагчдад тайлбарлан таниулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим програмыг нэвтрүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтэс/Т.Батбилэг/-т, бэлтгэл ажлыг ханган, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
5. Програмыг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, програмын байнгын хэвийн ажиллагааг хангахад шаардагдах зардлыг жил бүр улсын төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт тусган санхүүжүүлж байхыг Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газар /Э.Содномжамц/, Нийгмийн эрүүл мэндийн газар /Э.Галбадрах/, Халдварт өвчин судлалын үндэсний төв

080844

/Д.Нямхүү/, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт /-т даалгасугай.

САИД  Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 05 сарын 16 өдрийн  
А/191 дугаар тушаалын хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ  
ПРОГРАМЫГ НЭВТРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтрах байгууллага
Нэг. Бэлтгэл ажил				
1	Ховд, Өвөрхангай аймаг, нийслэлийн Хан-уул дүүрэг, "Өргөө" амаржих газарт цахим програмыг туршин нэвтрүүлэх	2018 оны 5-6 дугаар сар	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
2	"Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим програмыг ашиглах журам"-ыг боловсруулах, батлах	2018 оны 5-6 дугаар сар	ЭМЯ	ХӨСҮТ
3	Туршин нэвтрүүлсэн талаарх үр дүн, анхаарах асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналтай танилцах, програмыг хэрэглэх эсэх талаар дүгнэлт гаргах	2018 оны 5-6 дугаар сар	ЭМЯ-ны Мэдээллийн техникийн хороо, Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны зохицуулах зөвлөл	ХӨСҮТ
4	Компьютер, принтер, интернетийн холболтыг шалгах, бэлэн байдлыг хангах	2018 оны 5-6 дугаар сар	ЭМБ-ууд	Аймаг, нийслэлийн ЭМГ
5	Сервер компьютерийг Үндэсний дата төвд байршуулах, бэлэн байдлыг хангах	2018 оны 6-7 дугаар сар	ХӨСҮТ	ЭМЯ ДЭМБ
6	Дархлаажуулалтын мэдээллийн сан бүрдүүлэх: <ul style="list-style-type: none"> <li>• Харьяаллын 3 хүртлэх насны хүүхдийн бүртгэлийг шинэчлэх, түр оршин суугч, бүртгэлгүй хүүхдийг бүртгэлжүүлэх;</li> <li>• Хүүхдийн эхийн овог нэр, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаарын жагсаалтыг бэлтгэх;</li> <li>• Хүүхэд бүрийн</li> </ul>	2018 оны 5-8 дугаар сар	Өрх, сумын ЭМТ	Дүүргийн ЭМТ, аймаг нийслэлийн ЭМГ, ХӨСҮТ

	“Урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ”-г “Эх хүүхдийн дэвтэр”, “Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн бүртгэл”-тэй тулгаж, мэдээлэл бүрэн бус тохиолдолд нөхөж бичих, дахин гэрчилгээжүүлэх;			
7	Цахим програмыг хэрэглэх гарын авлагыг шинэчлэн сайжруулах, хэвлүүлэх, түгээх	2018 оны 8-9 дүгээр сар	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
8	<p>Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим програмыг нэвтрүүлэх сургалт зохион байгуулах:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дархлаажуулалтын үйл ажиллагаанд цахим програмыг нэвтрүүлэх үр ашиг, мэдээ мэдээллийг шийдвэр гаргахад ашиглах чиглэлээр аймаг, нийслэлийн ЭМГ-ын удирдах ажилтнуудыг;</li> <li>• Дархлаажуулалтын хамралтыг хянах, дүн шинжилгээ хийхэд цахим програмыг хэрэглэх чиглэлээр аймаг, нийслэл, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтнүүдийг;</li> <li>• Цахим програмыг дархлаажуулах үйл ажиллагаанд өдөр тутам ашиглах, хамрагдвал зохих хүүхдийг тооцох чиглэлээр өрх, сумын ЭМТ, нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, амаржих газрын дархлаажуулалт хариуцсан эмч, вакцинагор сувилагч нарыг сургах</li> </ul>	2018 оны 7-9 дүгээр сар	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ

9	Үе шаттай нэвтрүүлэх төлөвлөгөөний дагуу сонгосон аймаг, дүүрэгт бэлтгэл ажлыг үнэлэх дэмжлэгт хяналт хийх	2018 оны 7-8 дугаар сар	Аймаг, нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ
<i>Хоёр. Цахим програмыг нэвтрүүлэх</i>				
10	Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим програмыг нийслэлийн хэмжээнд нэвтрүүлэх	2018 оны 8-12 дугаар сар	Холбогдох ЭМБ-ууд	Нийслэлийн ЭМГ, ХӨСҮТ
11	Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим програмыг 21 аймагт нэвтрүүлэх	2019 оны 1-3 дугаар сар	Холбогдох ЭМБ-ууд	Аймгийн ЭМГ, ХӨСҮТ
12	Програмын ашиглалт, 0-3 хүртлэх насны хүүхдийн мэдээллийн сангийн бүрдэлтэд хяналт тавих, ажлын байранд нь сургах	2018 - 2019 он	Аймаг, нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ
13	Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим програмыг улсын хэмжээнд нэвтрүүлсэн явцыг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулах	2019 оны 6-9 дүгээр сар	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
14	Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим програмын хэрэгжилтэд үнэлгээ хийх	2019-2020 оны 1-3 сар	ХӨСҮТ	ЭМЯ